*Холбоо барих зохиогч: g.bayarmaa@num.edu.mn, <https://orcid.org/0000-0001-6550-657X>

Хураангуй. Малын гаралтай хүнс, тэжээлийн бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдэх, залилан мэхлэх явдал гарч, малын гаралтай өвчин дамжих эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан малын гаралтай бүтээгдэхүүнийг чанарын болон тоон илрүүлэх технологи нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах судалгааны чухал сэдэв болж байна. Арван төрлийн амьтны митохондрийн геномын бүрэн дарааллыг харьцуулж, шинжлэн, үхрийн өвөрмөц праймерууд болон пробьг сонгон, бодит хугацааны полимеразын гинжин урвал (ПГУ) ашиглан үхрийн гаралтай сүүний орцыг тодорхойлох зорилготой энэ судалгааны ажлыг хийлээ. Үр дүнд нь үхрийн сүүний гаралтай орцыг илрүүлэхэд зориулж боловсруулсан хос праймер болон проб нь өвөрмөц бөгөөд мэдрэмтгий болохыг харуулсан. Энэ арга нь нэг пикограм ДНХ-ийг илрүүлэх чадвартай. Үхрийн сүүн, махан бүтээгдэхүүнд үхрийн гарал үүслийг тоон аргаар илрүүлсэн үр дүнгээс үзэхэд тус арга нь тоон илрүүлэх чадвар сайтай болохыг харуулж байна.

Түлхүүр үгс: үхрийн гаралтай найрлага, үхрийн өвөрмөц праймер, проб, TaqMan

Хүлээн авсан 2023.03.22; хянан тохиолдуулсан 2023.08.30; зөвшөөрсөн 2023.11.02

© 2023 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

Оршил

Сүүн бүтээгдэхүүн нь үнээний сүү, хонины сүү зэргийг үндсэн түүхий эд болгон хэрэглэж, витамин, эрдэс бодис, бусад туслах материалыг зохих хэмжээгээр нэмж, хууль тогтоомж, зохих журмын дагуу боловсруулсан бүтээгдэхүүн юм [1]. Сүү, цагаан идээ нь хүнд зайлшгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн юм. Тэжээллэг чанар сайтай, тааламжтай амттай, дархлаа сайжруулах чадвартай тул хэрэглэгчид дуртай байдаг [2]. Сүүлийн жилүүдэд хонины сүү [3], [4], ямааны сүү [5], [6], одос үхрийн сүү [7], [8], сарлагийн сүү [9], [10], гүүний саам [11], [12], илжигний сүү [13], [14], тэмээний сүү [15], [16] нь тэжээллэг чанар сайтай, өвөрмөц амт, олон төрлийн ашигтай элементүүд агуулдаг учраас хэрэглэгчдийн дунд түгээмэл болж байна.

Сарлаг, тэмээний сүү зэрэг нь боловсруулах үйлдвэр цөөн, сүүний гаралт хязгаарлагдмал боловч хэрэглэгчдийн эрэлт ихтэй учраас үнээний сүүнээс арав гаруй дахин илүү үнэтэй байдаг. Төрөл бүрийн малын гаралтай сүү, цагаан идээний үнийн зөрүү нь үйлдвэрлэгчид болон хууль бус худалдаа эрхлэгчдийг

хямд үнэтэй сүү цагаан идээг өндөр үнэтэй сүү, цагаан идээгээр орлуулахад хүргэж байгаа нь шударга худалдааны зах зээлийг алдагдуулаад зогсохгүй, эрх ашгийг зөрчиж байна. Мөн хэрэглэгчдийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй.

Сүү, цагаан идээний гарал үүсэл, орц найрлагыг буруу мэдээлэх байдлаар залилан мэхлэх явдал түгээмэл байгаа тул сүү, цагаан идээний гарал үүслийг үнэн зөв тодорхойлох арга технологийг бий болгох нь нэн чухал юм [17], [18]. Одоогийн байдлаар амьтны гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг илрүүлэх аргууд нь дээж дэх тодорхой уураг, ДНХ-ийг илрүүлэх, шинжлэхэд үндэслэдэг фермент холбоот эсрэг биеийн урвал (ФХЭБУ), полимеразын гинжин урвал (ПГУ), бодит хугацааны полимеразын гинжин урвал (БХ-ПГУ), электрофорез, хроматограф, масс спектрометр зэрэг юм. Бодит хугацааны полимеразын гинжин урвал нь илрүүлэх чадвар, үр ашиг, мэдрэг чанар өндөр, өвөрмөц шинж чанараар бусад аргуудаас давуу юм. Iijima нар [19] 18S рРНХ, Girish нар [20] митохондрийн 12S рРНХ генийн ДНХ-ийн дарааллыг тодорхойлж, хүнсний бүтээгдэхүүн

дэх амьтан, ургамлын гаралтай бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох аргыг боловсруулсан. Агуа нар [21] холимог махны дээж дэх гахайн махны орц найрлагыг чанарын болон тоон байдлаар илрүүлэх TaqMan бодит хугацааны ПГУ-д суурилсан технологийг боловсруулсан.

Энэхүү судалгаанд хонь, үхэр, сарлаг, одос үхэр, гахай, тахиа, нугас, адуу, туулай, галууны митохондрийн геномын бүрэн дарааллыг харьцуулан үхрийн гаралтай орц найрлагыг чанарын болон тоон байдлаар илрүүлэх өвөрмөц праймер, пробын хослолыг сонгож, эдгээр праймер, проб дээр үндэслэн сүү, цагаан идээ, махны дээж дэх үхрийн гарал үүслийг шалгах, илрүүлэхэд тохиромжтой аргыг боловсруулсан.

Судалгааны материал, арга зүй

Сүү, зөөхийн дээжийг Шилийн хот дахь фермерийн захаас худалдан авч туршилтад шууд ашигласан. Махны дээжийг Шилийн хот дахь фермерийн захаас болон малчнаас худалдаж авсан.

Сүү, цагаан идээний боловсруулалт

Шинжилгээнд хамрагдах сүүний дээж 100 мл, зөөхийн дээж 100 мг хэмжин авч, 4°C-т 4800 g, 10 мин хурдтай центрифугидсэн. Шингэнийг асгаж, тунадсыг PBS (30 мл)-аар уусгаж, 4°C, 4800 g хурдтай 10 мин центрифугидсэн. Дараа нь тунадас дээр PBS (30 мл) ба ОР эмульгатор (emulsifier) 10 мл нэмээд 4°C температурт 10 минутын турш угаасны дараа дээрхитэй адил центрифугдэж, дахин 2 удаа PBS (30 мл) -аар угааж (4°C, 4800 g, 10 мин), тунадсыг хадгална.

Геномын ДНХ ялгах

Сүү, зөөхийн дээжээс СТАВ (цетилтриметиламмонийн бромид) аргыг хэрэглэн геномын ДНХ ялгасан. Тунадсыг 1,5 мл тюбед хийгээд, 800 мкл ДНХ лизис буфер (1% СТАВ, 50 mM трис, 13.5 mM Na₂EDTA, 0.7 M NaCl, pH 8.0) нэмж холин, 65°C температурт 30 минут байлган, үе үе сэгсэрч хольсон. 13000 эрг/мин-д 5 минутын турш центрифугдэж, дээд давхаргыг цэвэр тюбе руу шилжүүлэн, ижил хэмжээний хлороформ/изоамилийн спирт (24:1) нэмээд сайтар хольж, 5

минутын турш 13000 эрг/мин-д центрифуг хийж, дээд давхаргыг авч, ижил эзлэхүүнтэй изопропанол нэмж, сайтар хольж, 13000 эрг/мин-д 5 минутын турш центрифуг хийж, дээд давхаргыг хаяж, 75% этилийн спиртээр нэг удаа угааж, агаарт хатааж, ddH₂O-д уусгаж, -20°C хэмд хадгалсан. ДНХ-ийн концентрац ба цэвэршилтийг 2000c NanoDrop спектрофотометр (Thermo Fisher, USA) ба агароз гель электрофорезоор шалгаж, ДНХ-ийг цаашдын шинжилгээнд зориулж 100 нг/ мкл байхаар шингэлэв. MagAttract HMW DNA kit (QIAGEN) болон TaKaRa MiniBest Universal Genomic DNA isolation kit-ийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу геномын ДНХ ялгахад ашиглав. TaKaRa MiniBest Universal Genomic DNA isolation kit-ийг ашиглан махны эдийн дээжээс геномын ДНХ ялгасан. Гель электрофорезийг Trans 15K ДНХ маркер (Beijing Quanshi Gold Biotechnology Co, LTD), дээж тус бүрээс ойролцоогоор 600 нг ДНХ-ийг 0.8%-ийн агароз гельд гүйлгэн, 10 минут этидиум бромидоор будаж, зургийг (imaging analyzer, Thermo Fisher, USA) авсан.


Праймер, проб

Судалгаанд үхрийн (*Bos taurus*) митохондрийн рРНХ генийн дараалалд зохиосон праймер, проб ашиглав. GenBank-ийн өгөгдлийн санд хадгалагдаж буй митохондрийн ДНХ-ийн дараалалд харьцуулалт хийж, Primer Premier программ ашиглан рРНХ генийн дараалалд праймер болон проб ашиглан сонгож, Ruibiotech компанид (Бээжин, Хятад) нийлэгжүүлсэн. NCBI (Биотехнологийн мэдээллийн үндэсний төв)-ийн BLAST (Local Alignment Search Basic Tool) программ ашиглан праймер, пробын өвөрмөц байдлыг шалгасан. Үхрийн өвөрмөц пробыг 5' төгсгөлд HEX, 3' төгсгөлд BHQ флюоресцент будгаар тэмдэглэсэн. Үхрийн митохондрийн рРНХ генийн (LC745718.1 ба

1-р хүснэгт. Үхрийн өвөрмөц праймер ба пробын дараалал

	Дараалал 5' → 3'
Шууд праймер	CCCAGTACGAAAGGACAAGAG
Урвуу праймер	GGAGAGGATTGGAATCTCTGG
Проб	^a HEX-AGACAACCAATGATAACATCT-CAACTG- ^b BHQ ₂

Тайлбар: ^aHEX, hexachloro-6-carboxyfluorescein, ^bBHQ₂, black hole quench group



1-р зураг. *Bos taurus* митохондрийн геном дэх үхрийн өвөрмөц праймер ба пробын байрлал.

LC745515.1) праймер ба пробын хэсгийг 1-р зураг, дарааллыг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Бодит хугацааны ПГУ

Бодит хугацааны ПГУ-ыг нийт 20 мкл эзэлхүүнээр хийсэн: TransStart qPCR SU-Premix 2 мкл, үхрийн шууд праймер (10 мкМ) 1.0 мкл, үхрийн урвуу праймер (10 мкМ) 1.0 мкл, проб (10 мкМ) 1.0 мкл, ДНХ (100 нг/мкл) 1.0 мкл. ПГУ-ын нөхцөл нь: 94°C-т 30 сек денатураци хийсний дараа 94°C-т 5 сек, 60°C-д 31 сек, 40 цикл

Илрүүлэх хязгаар ба тоон шинжилгээ

Гурван өөр аргаар ялгаж авсан сүү, зөөхийн ДНХ-ийг ddH₂O-ээр градиентээр шингэлсэн. Шингэрүүлэлт тус бүрт 10 дахин, нийт 5 удаа шингэлэв (10 нг/мкл, 1 нг/мкл, 0.1 нг/мкл, 0.01 нг/мкл, 0.001 нг/мкл). Өөр өөр шингэрүүлэлтийн зэрэг бүхий зургаан дээжийн ДНХ-ийг бодит хугацааны флюоресцент ПГУ-аар олшруулахад ашигласан. Стандарт муруйг St аргаар тодорхойлсон.

Мэдээлэл боловсруулах


Олшруулалтын муруй болон St утгыг 7300Plus бодит хугацааны ПГУ-ын (ABI, USA) олшруулалтын программыг ашиглан шинжлэв. Туршилт бүрт гурван зэрэгцээ туршилт явуулсан бөгөөд үр дүнг дундаж ± стандарт хазайлтаар илэрхийлэв.

Үр дүн

Дээжийн ДНХ-ийн концентрац ба цэвэршилт

СТАВ арга, ТаKaRa болон MagAttract кит хэрэглэж сүү, зөөхийн дээжээс ойролцоогоор 100 нг/мкл концентрац бүхий ДНХ ялгаж авсан (**2-р хүснэгт**). Сүүний дээжээс СТАВ арга болон ТаKaRa китээр ялгаж авсан ДНХ-ийн A_{260/A280} утга нь 1.8-тай ойролцоо байсан нь ДНХ-ийн цэвэршилт өндөр байгааг харуулж байна. MagAttract китээр

ялгаж авсан сүүний ДНХ-ийн A_{260/A280} харьцаа 1.6 орчим байна. Эдгээр гурван арга нь сүү, зөөхийн дээжээс концентрац өндөр, цэвэршилт сайтай ДНХ ялгах боломжтойг харуулж байна. ТаKaRa болон MagAttract кит ашиглан ялган авсан ДНХ нь уураг зэрэг хольцоор бохирдсон байгаа нь силика мембран, соронзон бөмбөлгүүд нь уураг, өөх тосыг шингээж байгаа болохыг харуулж байна. Ижил аргаар өөр өөр дээжээс (сүү, зөөхий) ялгасан ДНХ нь ялгаатай цэвэршилттэй байсан нь зөөхий нь сүүнээс илүү уураг, өөх тос агуулдаг бөгөөд энэ нь силика мембран, соронзон бөмбөлөг нь уураг, өөх тосыг илүү шингээж, A_{260/A280} утгыг багасгасан байх магадлалтай. Агарозын гель электрофорезоор гурван өөр аргаар ялгаж авсан ДНХ-ийн задралыг шалгасан. 2A-р зурагт үзүүлснээр СТАВ аргаар гаргаж авсан сүү, зөөхийн ДНХ задарч, тодорхой ДНХ-ийн зурвас харагдахгүй байв. ТаKaRa кит ашиглан сүү, зөөхийн дээжээс ялган авсан ДНХ хагас задарсан (2B-р зураг) байгаа бол сүүний дээжээс MagAttract китээр ялгаж авсан ДНХ (2C-р зураг) бүрэн бүтэн байдал сайтай (задраагүй), харин зөөхийн ДНХ бага зэрэг задарсан байна. Дээрх үр дүнгээс үзэхэд нэг адил дээжид ДНХ ялгах гурван аргын дотроос MagAttract кит ашигласан арга нь илүү сайн үр дүнтэй байна.



2-р зураг. Сүү, зөөхийний дээжээс ДНХ-ийг СТАВ аргаар (A), ТаKaRa кит (B), MagAttract кит (C) ашиглан ялгаж авсан ДНХ-ийн электрофореграмм. М:Транс 15К ДНХ маркер; 1-3: сүүний дээж 1-3, 4-6: зөөхийний дээж 1-3.

Үхрийн гаралтай орц найрлагыг бодит хугацааны ПГУ-аар илрүүлэх

Үхрийн өвөрмөц праймер болон проб ашиглан


2-р хүснэгт. Сүү, зөөхийн ДНХ-ийн концентрац ба цэвэршилт

Дээж	СТАВ		TakaRa kit		MagAttract kit	
	ДНХ концентрац (нг/мкл)	A _{260/280}	ДНХ концентрац (нг/мкл)	A _{260/280}	ДНХ концентрац (нг/мкл)	A _{260/280}
Сүү 1	112.6	1.83	78.4	1.83	106.7	1.64
Сүү 2	118.5	1.84	127.9	1.84	99.6	1.63
Сүү 3	116.4	1.82	125.1	1.83	105.2	1.66
Зөөхий 1	122.3	2.03	115.6	1.24	118.7	1.54
Зөөхий 2	117.4	1.95	89.5	1.27	123.6	1.50
Зөөхий 3	120.4	1.98	120.4	1.25	120.4	1.56

зургаан үхрийн дээжээс авсан сүү, зөөхий, махны геномын ДНХ-ийг шингэрүүлэгчийг загвар болгон ашиглан бодит хугацааны флюоресцент тоон ПГУ-аар (TaqMan пробын арга) илрүүлсэн. Үхрийн сүү, цөцгий (3А-р зураг), махны (3В-р зураг) дээжид олшруулалтын муруй ажиглагдаж, бусад дөрвөн өөр малын сүү, долоон өөр амьтны булчингийн эдэд олшруулалтын муруй ажиглагдаагүй (**3-р зураг**). Бодит хугацааны ПГУ-аар илрүүлсэн үнээний сүү, зөөхий, махны дээжийн St утгыг 3-р хүснэгт үзүүлэв. Сүү, зөөхийн дээжийн St утгууд (зургаан дээж, тус бүрийг гурван удаагийн давталттай туршсан) бүгд 0-ээс их ба 35-аас бага байсан нь дээжийн гарал үүсэл нь амьтны гарал үүсэлтэй нийцэж байгааг харуулж байна. Амьтны гарал үүслийн шинжилгээний үндэсний стандартын дагуу (SN/ T2051-2008 “Хүнс, гоо сайхан, тэжээлийн бүтээгдэхүүн дэх үхэр, хонь, гахайн гаралтай орц, найрлагыг илрүүлэх; БНХАУ-ын экспорт, импортын хяналт, хорио цээрийн стандарт”) болон өмнөх судалгааны үр дүнгийн [6] дагуу олшруулалтын муруй байгаа үед дээжийн St утга 0-тэй тэнцүү биш, 35-аас бага байвал дээжийг харгалзах эх үүсвэр гэж тодорхойлно. Дөрвөн малын (хонь, гүү, одос үхэр, тэмээ) сүүний ДНХ болон долоон амьтны (гахай, хонь, адуу, тахиа, нугас, туулай, галуу) булчингийн геномын ДНХ-ийн St утга 0 байгаа нь эдгээр дээжийг үхрийн гаралтай биш болохыг харуулж байна. Энэхүү судалгааны үр дүн нь бидний боловсруулсан праймер болон пробыг ашиглан сүү, цөцгий дэх үхрийн гаралтай орц найрлагыг илрүүлэхэд үр дүнтэй болохыг харуулж байна.

Бодит хугацааны ПГУ-ын мэдрэг чанар

Үхрийн сүүний геномын ДНХ-ийг градиентээр 10¹-10⁷ дахин шингэлж, үхрийн гаралтай орц найрлагын мэдрэг чанарыг илрүүлэх туршилт




3-р хүснэгт. Сүү, зөөхий, махны эдийн дээжийн ДНХ ба St-ийн хандалтын үнэлгээ


Дээж	ДНХ концентрац (нг/мкл)	A ₂₆₀ / A ₂₈₀	St утга
Сүү 1	103.7	1.64	16.19 ± 0.84
Сүү 2	99.6	1.62	21.52 ± 0.58
Сүү 3	105.1	1.66	25.38 ± 0.35
Зөөхий 1	118.7	1.54	29.95 ± 0.42
Зөөхий 2	123.6	1.50	33.13 ± 0.29
Зөөхий 3	120.4	1.55	35.59 ± 0.40
Үхрийн мах 1	103.2	1.87	13.23 ± 0.04
Үхрийн мах 2	108.2	1.89	14.33 ± 0.14
Үхрийн мах 3	108.2	1.87	14.33 ± 0.04
Үхрийн мах 4	106.5	1.86	13.33 ± 0.03
Үхрийн мах 5	103.2	1.87	13.23 ± 0.04
Хонины сүү	119.4	1.87	-
Гүүний сүү	110.1	1.92	-
Одос үхрийн сүү	111.9	1.78	-
Ингэний сүү	119.7	1.88	-
Гахайн мах	129.1	1.89	-
Хонины мах	116.4	1.87	-
Адууны мах	121.1	1.89	-
Тахианы мах	105.9	1.88	-
Нугасны мах	122.7	1.90	-
Туулайн мах	109.4	1.86	-
Галуун мах	102.8	1.84	-

Жич: “-” илрээгүй.

хийхэд үхрийн геномын ДНХ (100.000 00 нг), 10¹ (10.000 00 нг), 10² (1.000 00 нг), 10³ (0.100 00 нг), 10⁴ (0.0100 00 нг), 10⁵ дахин (0.001 00 нг) шингэрүүлсэн үед олшруулалтын муруй үүссэн ба шингэрүүлэлт ихсэх тусам баруун тийш шилжиж байсан (Зураг 4). 10⁶ (0.000 10 нг) ба 10⁷ (0.000 01 нг) дахин шингэрүүлэлтийн үед олшруулалтын муруй



3-р зураг. Үхрийн сүү, зөөхийн дээж дэх үхрийн гаралтай орц найрлагыг тодорхойлох; (А) сүү болон зөөхийн дээж, (В) махны эдийн дээж



4-р зураг. Үхрийн гаралтай орц найрлагыг илрүүлэх хязгаар

4-р хүснэгт. Үхрийн сүү, зөөхийн ДНХ-ийн илрүүлэх хязгаарын үр дүн

Концентрац	Ct утга	
	MagAttract кит	
	Сүү	Зөөхий
100	16.73 ± 0.40	16.15 ± 0.85
10	21.30 ± 0.13	21.24 ± 0.39
1	23.81 ± 0.17	25.38 ± 0.24
0.1	27.73 ± 0.29	29.95 ± 0.32
0.01	30.21 ± 0.13	33.23 ± 0.19
0.001	34.45 ± 0.30	35.47 ± 0.40
0.0001	-	-
0.00001	-	-

Жич: “-” илрээгүй.

5-р хүснэгт. Сүү, зөөхий стандарт муруйн налуу, үр ашиг ба корреляцийн коэффициент (r^2)

Test item	Ct утга	
	Сүү	Зөөхий
Зөөхийн стандарт муруй (r^2)	0.9949	0.9993
Налуугийн коэффициент	-3.363	-3.55
ПГУ-ын үр ашиг (%)	98.31	91.16

6-р хүснэгт. Махан бүтээгдэхүүн дэх үхрийн тоон үзүүлэлт

Дээж	Ct утга	Илэрсэн массын концентрац (нг/мкл)
Үхрийн борц	15.47	262.03
	15.31	307.03
	15.92	207.93
	15.74	217.78
	15.39	276.42

ажиглагдаагүй. Бодит хугацааны ПГУ-аар дээжийн гарал үүслийг илрүүлэх шингэрүүлсэн дээжийн Ct утгыг Хүснэгт 4-т үзүүлэв. ДНХ-ийн концентрац 100.000 00 нг-аас 10^5 дахин шингэлсэн (0.001 00

нг) утгын хооронд Ct утга тэгтэй тэнцүү биш, 35-аас бага байж, Ct утга ДНХ-ийн концентрацын шингэрүүлэлтийг даган аажмаар нэмэгдэж байна. Үхрийн сүү, зөөхийн геномын ДНХ-ийг 10^6 ба 10^7 дахин шингэлж үзэхэд Ct-ийн утга 0 байсан. Дээрх үр дүнгээс үзэхэд үхрийн өвөрмөц праймер, проб дээр үндэслэсэн үхрийн ДНХ-ийг илрүүлэх арга нь 0.001 нг үхрийн ДНХ-ийг амжилттай илрүүлж, зорилтот ДНХ-ийг танихад мэдрэг чанар өндөртэй байна.

Үхрийн гаралтай орц найрлагын тоон илрүүлэлт

Сүү, зөөхийн геномын ДНХ-ийн стандарт муруйг ашиглан сүүн бүтээгдэхүүн дэх үхрийн сүүний орцын хэмжээг тодорхойлж болно. Үхрийн ДНХ-ийн концентрацын зургаан цуврал шингэрүүлэлтийн графикийг үхрийн гаралтай орц найрлагын хэмжээг тодорхойлох муруйг зурахад ашигласан (хүснэгт 5). Харгалзах Ct утга болон үхрийн зөөхийн стандарт муруйн дагуу сүү, зөөхий дэх үхрийн гаралтай бүрэлдэхүүн хэсгүүдийн тоон утгыг тооцоолж болно. Боловсруулсан махан бүтээгдэхүүн (үхрийн борц) дэх үхрийн махны орцыг бодит хугацааны ПГУ-аар тоон утгыг хэмжихэд үхрийн махны стандарт муруйгаас тооцоолсон харгалзах массын концентрац нь бодит массын концентрацын утгатай сайн тохирч байв (6-р хүснэгт). Дээрх үр дүнгээс үзэхэд бидний сонгосон праймер, проб нь сүү, цагаан идээ дэх үхрийн гаралтай орц найрлагыг тодорхойлох, тоон утгаар илрүүлэх чадвартай болохыг харуулж байна.

Хэлэлцүүлэг

Хүнсний бүтээгдэхүүн дэх амьтны орц найрлагыг илрүүлэхэд бодит цагийн ПГУ-ын технологийг ашиглах нь хяналтын байгууллагуудад чухал шаардлагатай. Энэхүү технологи нь хүнсний аюулгүй байдлын менежментийг сайжруулах, сүүний зах зээл дэх хуурамч сүүн бүтээгдэхүүний асуудлыг шийдвэрлэх шинжлэх ухаанд үндэслэсэн, үр дүнтэй арга юм.

Одоогийн байдлаар амьтны гаралтай орц найрлагыг илрүүлэх нь ихэвчлэн стандарт ПГУ болон ДНХ-тэй холбогддог флуоресцент будаг ашиглах бодит хугацааны ПГУ дээр суурилдаг. Сүүлийн жилүүдэд гаралтай орц найрлагыг тодорхойлоход TaqMan проб дээр суурилсан технологийг ашиглах нь нэмэгдэж байна. TaqMan проб ашиглах бодит хугацааны ПГУ нь цэвэршилт сайтай ДНХ-ийн дээж, тухайн дээжид өвөрмөц праймер, пробьг хэрэглэдэг. Бодит хугацааны ПГУ-ын хоёр аргыг харьцуулахад TaqMan проб арга нь илрүүлэх чадвар илүү өндөр

байдаг.

Энэ судалгаагаар сүү, сүүн бүтээгдэхүүн дэх үхрийн сүүний орц найрлагыг хурдан, үнэн зөв, тогтвортой илрүүлдэг өвөрмөц байдал болон мэдрэг чанар өндөртэй бодит цагийн флуоресценцийн тоон ПГУ-ын аргыг бий болгосон. Lopez-Calleja [22] нарын судалгаагаар харьцуулахад ямааны сүүнд агуулагдах сүүний орцыг илрүүлэх хязгаар нь 0.5%-иар өндөр байна. Yijie [23] нарын холимог сүүнд үхрийн гарал үүслийг тодорхойлох праймер, пробын илрүүлэлтийн хязгаараас 1%-иар их байсан. Мах, махан бүтээгдэхүүн дэх үхрийн гарал үүслийг илрүүлэх хязгаар нь Zhang [24] нарын ашигласан праймер, пробтой харьцуулахад 0.035 нг-аар их байна. Мөн энэхүү судалгаанд боловсруулсан праймер, проб нь худалдаанд байгаа үхрийн махан хиамны орц найрлагыг үр дүнтэй тодорхойлж, уг аргын өвөрмөц чанар, өндөр мэдрэмжтэй, өргөн хэрэглээний боломжтойг харуулсан.

Дүгнэлт

Митохондрийн геномын рРНХ генийн нуклеотидын дарааллыг харьцуулан сонгосон үхрийн өвөрмөц проб нь бодит хугацааны ПГУ явуулахад үр дүнтэй байсан.

Судалгааны дээжид ашигласан шууд, урвуу праймер болон пробын зохистой харьцаа нь 1 нг:1 нг байв. Мэдрэг чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн уг арга нь 1 пикограмм үхрийн ДНХ-ийг илрүүлэх чадвартай болохыг тогтоосон.

Үхрийн өвөрмөц проб ашиглан үхрийн гаралтай орц найрлагыг илрүүлэх хурдан, үнэн зөв, тогтвортой бодит цагийн ПГУ-ын аргыг боловсруулсан.

Ашигласан бүтээл

[1] L. C. Liao, “Development of dairy products and HACCP System Certification of dairy products,” *Food Safety Guide*, vol. 21, pp. 61-62, 2017.

[2] J. L. Liu, “Development of polymerase chain reaction-based techniques to detect adulteration of goat milk with bovine milk,” Xi’an: Shaanxi University of Science and Technology, 2018.

[3] W. Y. Quan, H. L. Xia, S. Gang, “Nutritional and Therapeutic Properties of Goat Milk,” *Journal of Animal Science and Veterinary Medicine*, vol. 29, no. 1, pp. 66-67, 2010.

[4] Y. B. Wang, S. Xu, Y. M. Hou, “Research progress on the Nutritional Composition of Goat Milk,” *Chinese Journal of Food and Nutrition*, vol. 18 no. 10, pp 67-71, 2012.

[5] T. Chen *et al.*, “Functional probiotics of lactic acid bacteria from Hu sheep milk,” *BMC Microbiology*, vol. 20, no. 1, Jul. 2020, <https://doi.org/10.1186/s12866-020-01920-6>.

[6] A. Nudda *et al.*, “Effects of nutrition on main components of sheep milk,” *Small Ruminant Research*, vol. 184, p. 106015, Mar. 2020, <https://doi.org/10.1016/j.smallrumres.2019.11.001>.

[7] J. H. Dai *et al.*, “Research progress on nutrition and function of buffalo milk,” *Chinese Dairy Cows*, vol. 6, pp. 10-13, 2017.

[8] Q. Y. Li *et al.*, “Research progress on components and functional properties of buffalo milk,” *Food Science*, vol. 32, no. 3, pp. 305-309, 2011.

[9] F. Yang, Z. Luo, X. Shen, C. Liu, W.-Y. Huang, and S. Shuguo, “Study on Nutrition, Flavor Characteristics and Antioxidant Activity of Yak Milk Dregs at Different Elevations in Tibet,” *Science and Technology of Food Industry*, vol. 42, no. 11, pp. 81–88, Jun. 2021, <https://doi.org/10.13386/j.issn1002-0306.2020090265>.

[10] J. Zhang, M. Yang, D. Cai, Y. Hao, Z. Yang, “Composition coagulation characteristics and cheese making capacity of yak milk,” *Journal of Dairy Science*, vol. 103, no. 2, pp. 1276-1288, 2020.

[11] G. Liang *et al.*, “Study of bacterial and fungal community structures in traditional koumiss from Inner Mongolia,” *Journal of Dairy Science*, vol. 102, no. 3, pp. 1972-1984, 2019.

[12] L. Guo *et al.*, “Production technology, nutritional, and microbiological investigation of traditionally fermented mare milk (Chigee) from Xilin Gol in China,” *Food Science and Nutrition*, vol. 8, no. 1, pp. 257–264, Dec. 2019, <https://doi.org/10.1002/fsn3.1298>.

[13] Z. Wenwen *et al.*, “Chemical nutrients and bioactivity of donkey milk,” *Journal of Food Safety and Quality Inspection*, vol. 8, no. 12, pp. 4574-4581, 2017.

[14] Y. Y. Liu *et al.*, “Determination of physical and chemical properties and microorganisms in fresh donkey milk,” *Xinjiang Animal Husbandry*, vol. 32, no. 11, pp. 50-51, 2017.

[15] F. Benmeziane – Derradji, “Evaluation of camel milk: gross composition—a scientific overview,” *Tropical Animal Health and Production*, vol. 53, no. 2, p. 308, May 2021, <https://doi.org/10.1007/s11250-021-02689-0>.

[16] G. Liang *et al.*, “Comparative study of physicochemical composition and microbial

- community of khoormog, chigee, and airag, traditionally fermented dairy products from Xilin Gol in China,” *Food Science and Nutrition*, vol. 9, no. 3, pp. 1564-1573, 2021.
- [17] L. Guo *et al.*, “Simultaneous identification of bovine and equine DNA in milks and dairy products inferred from triplex TaqMan real-time PCR technique,” *Journal of Dairy Science*, vol. 101, no. 8, pp. 6776–6786, Aug. 2018, <https://doi.org/10.3168/jds.2018-14408>.
- [18] X. Hai *et al.*, “Triplex real-time PCR assay for the authentication of camel-derived dairy and meat products,” *Journal of Dairy Science*, vol. 103, no. 11, pp. 9841–9850, Nov. 2020, <https://doi.org/10.3168/jds.2019-17245>.
- [19] K. Iijima, K. Suzuki, K. Ozaki, H. Kuriyama, Y. Kitagawa, and H. Yamashita, “DNA analysis for identification of food-associated foreign substances,” *Journal of Food Quality*, vol. 29, no. 5, pp. 531–542, Oct. 2006, <https://doi.org/10.1111/j.1745-4557.2006.00091.x>.
- [20] P. S. Girish *et al.*, “Sequence analysis of mitochondrial 12S rRNA gene can identify meat species,” *Meat Science*, vol. 66, no. 3, pp. 551–556, Mar. 2004, [https://doi.org/10.1016/s0309-1740\(03\)00158-x](https://doi.org/10.1016/s0309-1740(03)00158-x).
- [21] M. Arya, I. S. Shergill, M. Williamson, L. Gommersall, N. Arya, and H. R. Patel, “Basic principles of real-time quantitative PCR,” *Expert Review of Molecular Diagnostics*, vol. 5, no. 2, pp. 209–219, Mar. 2005, <https://doi.org/10.1586/14737159.5.2.209>.
- [22] I. López-Calleja *et al.*, “Real-time TaqMan PCR for quantitative detection of cows’ milk in ewes’ milk mixtures,” *International Dairy Journal*, vol. 17, no. 7, pp. 729–736, Jul. 2007, <https://doi.org/10.1016/j.idairyj.2006.09.005>.
- [23] Y. J. Ren *et al.*, “Identification of four animal derived components in milk and dairy products,” *Chinese journal of food hygiene*, vol. 34, no. 4, pp. 663-667, 2022.
- [24] C. Zhang, M. L. Fowler, N. Scott, G. Lawson, and A. Slater, “A TaqMan real-time PCR system for the identification and quantification of bovine DNA in meats, milks and cheeses,” vol. 18, no. 9, pp. 1149–1158, Sep. 2007, <https://doi.org/10.1016/j.foodcont.2006.07.018>.